



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ**

14251 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
II хороо, Чингисийн өргөн чөлөө 11
Утас: 62263168, Факс: (976-11) 31-23-15
И-мэйл: info@mrtd.gov.mn, https://www.mrtd.gov.mn

2016. 8. 26. № 38-07-073/001

Г АВТО ЗАМЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗАРТ

Г Булган аймгийн Сэлэнгэ мөрний
437 урт метр төмөр бетон гүүрийн
ажлын зурагт өөрчлелт оруулсан тухай

Зам тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн шийдвэрийн дагуу Сэлэнгэ мөрний 437 урт метр төмөр бетон гүүрийн ажлын гүйцэтгэлийн явцад бүрдүүлсэн баримт бичигт үндэслэн дүгнэлт гаргасан болно.

Ашигласан баримт бичгийн жагсаалт:

1. Сэлэнгэ мөрний 437 урт метр төмөр бетон гүүрийн трассын дагуу хийгдсэн;
2. "Таван үндэс" ХХК-ийн инженер-геологийн 3Т17-534/12 дугаар дүгнэлт;
3. "Хотгор зам" ХХК-ийн 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 01/15/232 тоот албан бичиг;
4. Захиалагчийн 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 06/3761 тоот албан бичиг;
5. "ГБЭТ" ХХК-ийн 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн Г63/2015 тоот албан бичиг;
6. "Хотгор зам" ХХК-ийн 2016 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 16/36 тоот албан бичиг;
7. "Геологийн төв лаборатори"-ийн 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн шинжилгээний дүгнэлт;
8. Хяналтын инженерийн 2015 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дүгнэлт;
9. Зураг зохиогч "ГБЭТ" ХХК-ийн 2015 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн тайлбар;
10. "Таван үндэс" ХХК-ийн гаргасан 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн тайлбар.

Булган аймгийн Сэлэнгэ сумын Сэлэнгэ мөрний 437 урт метр төмөр бетон гүүрийн ажлыг гүйцэтгэж буй "Хотгор зам" ХХК нь 2015 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 01/15/232 тоот албан бичгээр гүүрийн өрөмдмөл суурийг хийх үед хөрсний нуралт ихээр үүсч, төлөвлөсөн төвшин хүртэл өрөмдөхөд хүндрэлтэй байгаа тул худган суурь болгон өөрчлүүлэх тухай хүсэлтийг тус яаманд /тухайн 3ТЯ/ ирүүлсэн байна.

Хяналт хэрэгжүүлэгч: "Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ

Зураг зохиогч байгууллага: "ГБЭТ" ХХК

Гүйцэтгэгч байгууллага: "Хотгор зам" ХХК

Гүүрийн ажил эхлэх хугацаа: 2015 оны 7 дугаар сарын 31-ний өдөр

Ажил дуусах хугацаа: 2016 оны 10 дугаар сарын 31-ны өдөр

Тодорхойлох нь:

Зураг зохиогч "ГБЭТ" ХХК нь захиалагчийн 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 06/3761 тоот, гүйцэтгэгчийн 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 01/15/232 тоот албан бичгээр гаргасан хүсэлтээр өрөмдмөл суурийн зураг төслийг худган суурь болгох тухай шийдлийг 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн Г63/2015 тоот албан бичгээр "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-т хүргүүлсэн байна

Сэлэнгэ мөрний Хойд салаан дээрх 202.5 урт метр ган төмөр бетон гүүрийн 4 ширхэг завсрын тулгууруудын худган суурийг суулгах явцад чулуулаг хадан хөрсний ўе таарсан учир цаашид төлөвлөсөн төвшин хүртэл үргэлжлүүлэн суулгах боломжгүй болсон тул холбогдох арга хэмжээ авч өгөх тухай 2016 оны 6 дугаар сарын 7-ны өдөр 16/36 тоот албан бичгээр захиалагч, зураг зохиогчид мэдэгдсэн байна.

Инженер-геологийн "Таван үндэс" ХХК-ийн гаргасан 2014 оны 3Т17-534/12 дугаартай судалгааны дүгнэлтэд хойд салааны өрөмдлөгийн 10 дугаар цооногт 4.8 метр дээр 2 тал руугаа үргэлжилсэн уналттай чулуун давхаргын илрэлтэй байгаа тухай тайланд тусгасан байна.

Гүүрийн худаг суулгах ажил удааширч гүйцэтгэгч өрөмдлөгийн "Эрдгео" ХХК-тай гэрээ байгуулан 4 худган сууринд худаг суусан төвшингээс доош 10 метр гүн 12 ширхэг өрөмдлөгийг хийлгэн чулууны шинжилгээ гаргуулахаар дээжийг "Геологийн төв лаборатори"-д хүргүүлсэн.

Гүйцэтгэгч нь шинжилгээний хариу гарах хүртэл ажил хийгдэхгүй болохыг 2016 оны 6 дугаар сарын 7-ны өдөр тус яамны АЗБХЗГ-т /хуучнаар АЗТБХЗГ, зураг зохиогчид/ мэдагдсэн байна.

Гүйцэтгэгч өрөмдлөгийн "Эрдгео" ХХК-тай гэрээ байгуулан 4 худган сууринд худаг суусан төвшингээс доош 10 метр гүн 12 ширхэг өрөмдлөгийг хийлгэн, "Геологийн төв лаборатори"-ийн 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдөр шинжилгээгээр элсэн чулуу, өгөрсөн хадан хөрс бүхий тогтоцтой байна гэж дүгнэлт гаргасан бөгөөд тухайн өрөмдлөг хийсэн байршил, авсан дээжийн мэдээлэл байхгүй байна.

"Геологийн төв лаборатори"-ийн 2016 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн шинжилгээний дүгнэлтийн үр дүнг харгалзан зураг зохиогч "ГБЭТ" ХХК-аас хадан хөрсний дээд гадаргууг 0.75-1.0 метр гүнд ухаж худаг суулгах нь зүйтэй гэсэн шийдлийг 2016 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 19/2016 тоот албан бичгээр тус яамны Авт замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, гүйцэтгэгч болох "Хотгор зам" ХХК-д хүргүүлсэн байна.

Дүгнэлт болгох нь:

Инженер-геологийн судалгааны гүйцэтгэсэн "Таван үндэс" ХХК-ийн 2014 оны 3Т17-534/12 дугаар судалгааны дүгнэлтэд хойд салааны өрөмдлөгийн 10 дугаар цооногт 4.8 метр дээр 2 тал руугаа урт үргэлжилсэн уналттай чулуун давхаргын илрэлтэй байгааг тайланд тусгасан боловч чулуун давхаргын уналтын өндөр, тархалт, үргэлжлэх зайлг тодорхойлоогүй байна.

Зураг зохиогч нь гүйцэтгэгчээс ирүүлсэн гүүрийн суурь, тулгуурт өрөмдлөг хийсэн тайлбар, фото зураг, нөхцөл байдлыг зэргийг судлан үзэж, цаашид гүйцэтгэгч уг гүүрийн тулгуурын өрөмдмөл суурийн ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгэх боломжгүй байдлыг харгалзан, зохиогчийн хяналт тавих “БНБД 11-04-15”-ын 3.1.6-ийн “Барилга байгууламжийн бат бэх, найдваржилт, чанарын шаардлагыг буруулахгүйгээр хийц, элемент, хэсэглэл материалыг өөрчлөх” гэсэн заалтыг үндэслэн өөрчлөлт оруулсан байна.

Инженер-геологийн “Таван үндэс” ХХК-ийн 2014 оны ЗТ17-534/12 дугаар судалгааны дүгнэлт, “Геологийн төв лаборатори”-ийн 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн шинжилгээний дүгнэлтээр гаргасан тогтоцтой хөрсний давхаргад нь гүүрийн батлагдсан ажлын зургаар өрөмдмөл суурийн ажлыг зориулалтын техник, технологи ашиглан гүйцэтгэх бүрэн боломжтой байсан байна.

Инженер-геологийн “Таван үндэс” ХХК-ийн 2014 оны ЗТ17-534/12 дугаар дүгнэлт, “Эрдгэо” ХХК-ийн өрөмдлөг хийж, “Геологийн төв лаборатори”-ийн гаргасан 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн шинжилгээний дүгнэлтээр хойд салааны 202.5 урт метр гүүрийн трассын дагуу хөрсний бүтэц зөрүүтэй байгаа тул дахин хяналтын өрөмдлөг хийлгэх ажлыг “Таван үндэс” ХХК, “Хоттор зам” ХХК-аар гүйцэтгүүлэх, өрөмдлөгийн үр дүнгийн тайлан, дүгнэлт гаргуулах ажлыг захиалагч хариуцах нь зүйтэй байна.

Авто замын хяналтын улсын байцаагч

Ж.Хуандаг

